

НИЙСЛЭЛИЙН АМГАЛАН АМАРЖИХ ГАЗАР

2017 ОНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ШИНЭЭР НЭВТРҮҮЛСЭН ТЕХНОЛОГИ, АРГА АРГАЧЛАЛЫН МЭДЭЭНИЙ НЭГДСЭН САН

№	Тэргүүн туршлага, бүтээлч санаа	Тасаг нэгж	Үр дүн	Бүртгэсэн сар, өдөр
1.	<p>Өвчтөн өөрөө удирдаж өвдөлт намдаах /PCA-Patient Controlled Analgesia/ эмчилгээний удирдамжийг боловсруулж, эмчилгээнд нэвтрүүлж байна. 2017 оны эхний 5 сард 125 хүнд хэрэглэсэн.</p> <p>Зорилго: Хагалгааны дараах өвдөлт намдаах зорилгоор хэрэглэгддэг олон төрлийн өвдөлт намдаах эмийн бодисын хэрэглээг хэвшүүлэх, өвдөлт намдаах эмчилгээнд шинэ арга нэвтрүүлэх</p> <p><u>Эмчилгээний давуу тал:</u></p> <ul style="list-style-type: none"> ➤ Өвдөлт намдаах эмийн бодисыг системчилснээр эмийн замбараагүй хэрэглээг багасгах ➤ Өвчтөн өвдөлт мэдрэх үедээ өвдөлт намдаах эмийг нэмэлтээр авах ➤ Өвчтөн өвдөлт мэдрэх байдлаас хамаарч эмийн бодисын хэмжээг титрлэж / шингэлж/ болох учраас эмийн гаж нөлөөг багасгах ➤ Өвчтөний шархны эдгэрэлт түргэн байх ➤ Эмнэлгийн ор хоног багасгах ➤ Цаг болон ажиллах хүчийг хэмнэх давуу талтай юм. 	Мэдээгүйжүүлгийн тасаг	Маш сайн.	2017
2.	<p>Үрэвслийн маркер CRP, RF, ASO шинжилгээг тоон утгаар тодорхойлж байгаа нь оношилгоо эмчилгээнд чухал ач холбогдолтой байна. Нийт 585 эх нярайд үрэвслийн маркерын шинжилгээ хийсэн байна.</p>	Нярайн тасаг	Сайн	2017
3.	<p>Нярайн уушигны дутмагшилтай төрсөн нярайд сурфактант эмчилгээ хийх -3 нярайд хийсэн.</p>	Нярайн тасаг	Сайн	2017

4.	Нярайн амьсгалын замын эмгэгийн эмчилгээнд небулайзер эмчилгээг 4 нярайд хэрэглэсэн.	Нярайн тасаг	Сайн	2017
5.	Тархи нугасны шингэний шинжилгээг уламжлалт аргаар хийж лабораторийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.	Нярайн тасаг	Сайн	2017
6.	Цус задралын анеми, үрэвсэлт эмгэг, үжил, ДВС зэргийн үед цусны мазокийг микроскопоор харан шинжилж тусламж үйлчилгээгээ сайжруулан ажиллаж байна.	Лаборатори	Сайн	2017
7.	Франц улсын эх баригч нар төрөлтөндөө оёдол тавих үедээ хэрэглэдэг тампоныг өөрийн төрөх эмнэлэгтээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Тампоны давуу тал нь умайн хүзүү таглаж тавьж оёдол тавих явдал юм.	Төрөх тасаг	Сайн	2017
8.	Япон-Монголын хамтарсан “JICA” төслийн хүрээнд сургалтанд хамрагдсан эх баригч Ч.Бадамхандын санаачлагаар төрөх эхчүүдийн тухай хяналт, мэдээллийн самбарыг шинээр хийж тавилаа.	Төрөх тасаг	Сайн	2017

Дүгнэлт.

2017 оны эхний хагас жилд шинэ санаа тэргүүн туршлага 8 –ийг нэвтрүүлж хэрэгжүүлсэн байна. Хэрэгжилтийн үр дүн сайн. Эмчилгээ үйлчилгээний чанарыг нэмэгдүүлсэн.

ЧАНАРЫН АЛБА